

**“ХААН БАНКНЫ НЭРЭМЖИТ ШИНЭ ОЮУТНЫ
ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР 2026-2027”****ӨРГӨДЛИЙН МАЯГТ****Хөтөлбөрийн зорилго, хамрах хүрээ:**

ХААН Банкнаас компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх бодлогын дагуу Тогтвортой хөгжлийн “Чанартай боловсролыг дэмжих” зорилгод чиглэн “ХААН Банкны нэрэмжит шинэ оюутны тэтгэлэгт хөтөлбөр 2026-2027”-ыг 20 дахь жилдээ нээлттэй зарлаж байна.

Уг хөтөлбөрийн хүрээнд Монгол орны 21 аймаг, Зүүнхараа, Замын-Үүд болон Улаанбаатар хотын Багануур дүүргийн ЕБС-ийн 12-р анги төгсөж буй 70 сурагчийг шалгаруулж, Монгол улсад магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн 1-р дамжааны сургалтын төлбөрийн тодорхой хувийг тэтгэлгээр олгох юм.

Тэтгэлэгт тэнцсэн эрх бүхий этгээд нь гадаадын их, дээд сургуульд суралцахаар болсон тохиолдолд тэтгэлгийг түдгэлзүүлэн дараагийн байрт шалгарсан тэтгэлэг горилогчид олгоно.

Тэтгэлгийн хэмжээ: 2,000,000 төгрөг

Тэтгэлэг хүсэгчид тавих үндсэн шалгуур:

- 2026 онд дунд сургуулиа төгсөх 12-р ангийн сурагч байх;
- Сурлагын голч дүн “В” буюу 85%, түүнээс дээш байх;
- 11-12-р ангидаа улс, аймаг, хотын олимпиад болон уралдаан тэмцээнд амжилт гаргасан, эсвэл анги хамт олноо хошуучлан оролцсон байх;
- Хувь хүний ур чадвар сайтай, олон нийтийн ажилд идэвх санаачлагатай оролцдог бол давуу тал гэж үзнэ.

Тэтгэлэг хүсэгчийн бүрдүүлэх материал:

1. Анкет, цээж зураг (3x4 хэмжээтэй);
2. 12-р ангийн анги удирдсан багшийн тодорхойлолт (анкетын хавсралт маягтын дагуу, анги удирдсан багшийн гарын үсэг эсвэл багш тодорхойлсон гэдгийг нотлох и-мэйлээр баталгаажуулах);
3. **“Миний Боловсрол, Миний Ирээдүй”** 500-гаас доошгүй үгтэй эсээ бичих (компьютер дээр шивэх, эсвэл гараар монгол хэлээр гаргацгай цэвэр бичсэн байна).
4. 11-р ангийн жилийн эцсийн дүн, 12-р ангийн эхний хагас жилийн **дүнгийн жагсаалт** (*энэхүү жагсаалт нь сургуулийн тамга тэмдэг, холбогдох удирдлагын гарын үсэг бүхий албан бичиг байна. Гараар бичсэн, дүн дутуу дүнгийн жагсаалтыг тооцохгүй*).
5. Улс, аймаг, хот, дүүргийн олимпиад, урлаг спортын уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилтыг гэрчлэх материалын хуулбар (үүнд зөвхөн сүүлийн хоёр жил буюу 2025, 2026 онд гаргасан амжилтыг тооцно. Хуулбарыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй, огноо, нэр, үзүүлсэн амжилт тод харагдаж байх);

Хугацаа хоцроож ирүүлсэн материалыг хүлээн авахгүй бөгөөд хүлээн авсан материалыг буцаан олгохгүйг анхаарна уу.

Сонгон шалгаруулалт:

- ХААН Банкны төлөөлөл болон хөндлөнгийн гишүүдээс бүрдэх тусгай комисс сонгон шалгаруулалт явуулна.
- Шалгарсан оюутнуудад эрхийн бичиг гардуулах бөгөөд элссэн их дээд сургуулийн томилолтын хуудас, биеийн байцаалтын хуулбарыг үндэслэн ХААН Банк Сан эрхийн бичгийг баталгаажуулна.
- Тухайн их дээд сургуулийн төлбөр ямар байхаас үл хамааран эрхийн бичигт заасан мөнгөн дүнг оюутнуудад тэтгэлэг болгон олгоно.

Материал хүлээн авах хугацаа:

Өргөдлийн материалыг **2026 оны 5-р сарын 6-наас 5-р сарын 20-ны өдрийн 17:00 цаг хүртэл** орон нутгийн ХААН Банкны салбар, тооцооны төвүүд дээр цаасан хэлбэрээр хүлээн авна.


Шалгаруулалтын дүнг зарлах:

Шилдэг 70 оюутны нэрсийг **2026 оны 5-р сарын 28-нд** ХААН Банкны вэбсайт, албан ёсны социал сувгуудаар мэдээлнэ.

ТЭТГЭЛЭГ ХҮСЭГЧИЙН АНКЕТ

1. Ургийн овог: Эцэг/Эх-ийн нэр: Нэр:
 2. Төрсөн огноо: 3. Регистрийн №: 4.Хүйс:
 5. Оршин суугаа хаяг /аймаг, сум, дүүрэг/:

 6. Сургууль: 7. Утас:
 7. И-мэйл хаяг: 9. Фэйсбүүк хаяг:
 10. Гэр бүлийн тухай мэдээлэл



№	Гэр бүлийн гишүүний нэр	Хэн болох	Ажил эрхлэлт /Сургууль	Регистр	Холбоо барих утас

11. Хэрэв танай гэр бүлд их дээд сургууль төгссөн эсвэл одоо суралцаж байгаа оюутан байгаа бол сургалтын төлбөрөө ямар хэлбэрээр төлсөн/төлж буй эсэхийг дугуйлна уу.
 а. Хувиараа
 б. Төрийн сангийн зээл, буцалтгүй тусламж
 в. Гадаад дотоодын байгууллагуудын нэрэмжит тэтгэлэг
 г. Бусад
12. Өөр тэтгэлэгт хамрагдахаар өргөдөл өгсөн эсвэл боломжтой эсэх: /Төрийн сангийн зээл, бусад байгууллагын нэрэмжит тэтгэлэг гэх мэт/

13. Цаашид суралцахыг хүсэж буй чиглэл:
14. Эцэг эхийн гар утас:
15. Яаралтай үед холбогдох утас:

Огноо:

Дээрх мэдээллийн үнэн зөвийг баталсан:/Тэтгэлэг хүсэгчийн гарын үсэг/
 /Эцэг эх, асран хамгаалагчийн гарын үсэг/

Жич: Банк нь Монгол Улсын Иргэний хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу иргэдийн мэдээллийг хуульд заасан онцгой тохиолдлоос бусад үед чандлан нууцлах үүрэгтэй.

АНГИ УДИРДСАН БАГШИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Тэтгэлэг хүсэгчийн:

Овог: _____

Нэр: _____

Тэтгэлэг хүсэгчийн талаар үнэн зөв, шударга мэдээлэл өгнө гэдэгт бид найдаж байна. Дараах асуултуудад хариулсны дараа Үнэлгээний хүснэгтийг бөглөнө үү. Тэтгэлэг хүсэгчийн талаарх нэмэлт мэдээллийг хавсаргаж болно. (Таны тодорхойлолт тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтанд голлох үүрэгтэй тул та дэлгэрэнгүй үнэлж, тайлбар бичнэ үү)

А. Асуултууд

1.Тэтгэлэг хүсэгчийг хэдэн жилийн өмнөөс хэрхэн мэдэх вэ?

2.Тэтгэлэг хүсэгчийн авьяас чадвар, давуу талыг та юу гэж үнэлдэг вэ?

3.Тэтгэлэг хүсэгчийн дутагдал ба сул тал юу вэ?

4.Тэтгэлэг хүсэгчийн цаашид сурч боловсрох хүсэл эрмэлзлэлийг та хэрхэн дүгнэх вэ?

5. Та тэтгэлэг хүсэгчийг ямар учраас энэхүү тэтгэлгийг авах үндэслэлтэй гэж үзэж байна вэ?

Б. Үнэлгээний хүснэгт**Тэтгэлэг хүсэгчийн ур чадварын талаарх Таны үнэлгээ**

Сонгох хариултаа /"+"/ гэж тэмдэглэнэ

Ур чадварын чиглэл	Маш сайн	Сайн	Дунд	Хэлж мэдэхгүй байна
1. Манлайлах чадвар				
2. Харилцааны чадвар				
3. Бусдыгаа уриалах, зохион байгуулах чадвар				
4. Тусч, хөдөлмөрч чанар				
5. Идэвх санаачилга				
6. Сурч боловсрох эрмэлзэл				
7. Нийгмийн идэвх				

Тодорхойлсон:**Анги удирдсан багш:**

Овог:.....

Нэр:.....

И-мэйл хаяг:.....

Гар утас:

Гарын үсэг:

Огноо:.....

